



I-VI/2021

Тархаасан: 2021 оны 8 дугаар сарын 13



Даатгалын хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар өслөө

Даатгалын хураамжийн орлого 2021 оны эхний хагас жилд 111.1 тэрбум төгрөгт хүрч, даатгалын нөхөн төлбөрт 29.0 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс даатгалын хураамжийн орлого 16.3 (17.2%) тэрбум төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 1.3 (4.5%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.


Даатгалын хураамжийн орлого 2021 оны 2 дугаар улиралд 72.2 тэрбум төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 18.1 (33.4%) тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 33.2 (85.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Даатгалын нөхөн төлбөрт 2021 оны 2 дугаар улиралд 16.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 4.6 (37.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 4.4 (35.4%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хүснэгт 1. Даатгалын үзүүлэлтүүд

	2020		2021*		2021* IV-VI	2021* I-VI
	IV-VI	I-VI	IV-VI	I-VI	2020 IV-VI	2020 I-VI
	сая төгрөг				хувь	
Хураамжийн орлого	54 123.7	94 799.4	72 182.2	111 138.7	133.4	117.2
Нөхөн төлбөр	12 096.1	27 739.6	16 676.0	28 992.9	137.9	104.5
Даатгуулагчид, мянган нэгж	339.4	668.1	294.4	671.7	86.7	100.5
Хувь хүн, мянган хүн	278.6	553.4	299.9	576.7	107.6	104.2

Зураг 1. Даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, тэрбум төгрөгөөр, жил бүрийн 2 дугаар улирлын эцэст



Даатгалын хураамжийн орлого 2021 эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 16.3 (17.2%) тэрбум төгрөгөөр өсөхөд хөрөнгийн даатгалын хураамжийн орлого 9.6 (58.5%) тэрбум төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийн орлого 5.3 (32.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Даатгалын нөхөн төлбөр 2021 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 1.3 (4.5%) өсөхөд хөрөнгийн даатгалын нөхөн төлбөр 1.8 (66.2%) тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөр 624.6 (5.3 дахин их) сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгалын нөхөн төлбөр 124.3 (32.7 дахин их) сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Даатгалын хураамжийн нийт орлогын 23.4 хувийг хөрөнгийн даатгал, 19.6 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 16.9 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, гэнэтийн осолын даатгал 14.1 хувийг эзэлж байна.

Даатгалын нийт нөхөн төлбөрийн 28.5 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 23.8 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 17.1 хувийг гэнэтийн осолын даатгал, хөрөнгийн даатгал 15.7 хувийг тус тус эзэлж байна.

Даатгуулагчид 2021 оны эхний хагас жилд 671.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.5 (0.5%) мянгаар өссөн байна. Даатгуулагчдын 85.9 хувь нь иргэн, 14.1 хувь нь хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж, байгууллага байна.

Ойлголт, тодорхойлолт:

Даатгалын нөхөн төлбөр: Гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө юм.

Даатгалын үйл ажиллагаа: Даатгалын гэрээний дагуу даатгагч нь хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагаа юм.

Даатгалын хураамж: Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг ойлгоно.



Эх үүсвэр: Санхүүгийн Зохицуулах Хороо

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 11 дүгээр сарын 17

Хавсралт:

Эдийн засгийн статистикийн газрын статистикч

А.Мөнхцэцэг

Утас: (976-51)-261565

Эдийн засгийн статистикийн газрын дарга

Э.Эрдэнэсан

Утас: (976-51)-266414



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212